

“Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого”-ыг  
шинэчлэн батлах тухай

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, ЦССҮТ-ийн Бүтэц, үйл ажиллагааны стандарт 6674:2017, Дунд хугацааны стратеги төлөвлөгөөг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн “Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлого”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг ханган, жил бүр Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж ажиллахыг Цусны чанар, аюулгүй байдлын алба /А.Амарзаяа/, алба, тасгийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод аудитор /С.Алтаннамар/ -т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

## **НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО**

### **Нэг. Үндэслэл**

ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандартын 5.2 Бодлого, 5.2.1 Чанарын бодлого боловсруулах, дээд удирдлага нь а) байгууллагын зорилго, төлөв байдалд тохирсон, стратегийн чиглэлийг дэмжих, b) чанарын зорилтуудыг бий болгох, боломжоор хангах, c) холбогдох шаардлагыг биелүүлэх үүргийг тусгах d) чанарын менежментийн тогтолцоог үргэлж сайжруулах үүргийг тусгасан чанарын бодлогыг бий болгож, хэрэгжүүлж мөрдөх, 5.2.2 Чанарын бодлогыг мэдээлэх а) баримтжуулсан мэдээлэл байдлаар хүртээмжтэй байх ба мөрдөж хадгалах,

ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартын 5.2 ХЭМАБ-ын бодлогыг дээд удирдлага бий болгох, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг хангах, а) байгууллагын зорилго, цар хэмжээ, төлөв байдал болон ХЭМАБ-ын эрсдэл ба боломжуудын онцлог шинж чанарт тохирсон, гэмтэл ба эсвэл эрүүл мэндийн хохирлоос сэргийлэхийн тулд ажлын аюулгүй, эрүүл нөхцлөөр хангах үүрэг амлалт, b) ХЭМАБ-ын зорилтуудыг тогтоохуйц агуулга, хүрээтэй байх c) хууль тогтоомжийн шаардлага болон бусад шаардлагыг биелүүлэх үүрэг амлалт, d) аюулыг арилгах ба ХЭМАБ-ын эрсдлийг бууруулах үүрэг амлалт, e) ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог байнгын сайжруулах үүрэг амлалт, f) ажилтнуудын, хэрэв байгаа бол тэдний төлөөллийн оролцоог хангах ба зөвлөлдөх үүрэг амлалт, ХЭМАБ-ын бодлого нь баримтжуулсан мэдээлэл байх гэж тус тус шаардсаныг үндэслэн энэ бодлогыг боловсрууллаа.

### **Хоёр. Хамрах хүрээ**

Цус цуглуулах, шинжлэх, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хадгалах, олгох, сургалт, зөвлөгөө болон эдгээрийг дэмжих бүхий л үйл ажиллагааг хамруулна.

### **Гурав. Бодлого**

Төвийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт нийцүүлэн, чанарын болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоо (Цаашид Нэгдсэн менежментийн тогтолцоо гэх)–г байнга сайжруулж, аюулыг илрүүлэн, эрсдлийг бууруулж, үйлчлүүлэгч, ажиллагсдад ээлтэй орчинг бүрдүүлнэ.

### **Дөрөв. Зорилго, зорилт**

**4.1 Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг хангаж, сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагад нийцсэн тусламж үйлчилгээ үзүүлж, тасралтгүй сайжруулах**

4.1.1. ISO 9001:2015 Чанарын менежементийн тогтолцоо, ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартуудын дотоод аудитыг жил бүр 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, илэрсэн үл тохирол, сайжруулах зөвлөмжийн дагуу залруулах арга хэмжээг заавал авч ажиллана.

- 4.1.2. Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартын хөндлөнгийн аудитад жил бүр хамрагдаж, илэрсэн үл тохирол, сайжруулах зөвлөмжийн дагуу залруулах арга хэмжээг авч ажиллана.
- 4.1.3. Үйлчлүүлэгчийн санал гомдол, сэтгэл ханамжийн судалгааг олон талт хэлбэрээр зохион байгуулж, хариу арга хэмжээ авч ажиллана.
- 4.1.4. Ажиллагсдын чадамжид тавих шаардлагыг шинэчлэн, хүний нөөцийн чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.1.5. Жил бүр үйл ажиллагааны эрсдэл боломжийг тооцоолж, аюулыг арилган, тогтмол сайжруулалт хийж ажиллана.
- 4.1.6. Нэгдсэн менежементийн тогтолцооны чиглэлээр нийт ажиллагсдад жилд 2-оос доошгүй удаа сургалт зохион байгуулан, ажиллагсдын оролцоог хангаж ажиллана.

#### **4.2 Тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, аюулгүй, үр дүнтэй цус, цусан бүтээгдэхүүнээр тасралтгүй хангана.**

- 4.2.1. Цусны донорын эгнээг өргөжүүлж, байнгын донорын эзлэх хувийг 60%-иас дээш байлгана.
- 4.2.2. Лабораторийн шинжилгээний 5–аас доошгүй олон улсын болон үндэсний чанарын гадаад үнэлгээнд тогтмол хамрагдана.
- 4.2.3. ЦЦБ-ийг чанарын болон ариун чанарын шинжилгээнд хамруулж, шинжилгээгээр тэнцэлтийг 95%-иас дээш байлгана.

#### **Тав. Бодлогын хэрэгжилтэд баримтлах зарчим**

- 5.1 Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмыг дээдлж, түүнийг сахин биелүүлдэг байх
- 5.2 Чанар, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн холбогдох хууль, тогтоомж, стандартыг хэрэгжүүлэх, байгууллагын бодлого, сонирхогч талуудын хэрэгцээ шаардлагыг хангаж, хүлээсэн үүргийг биелүүлэх
- 5.3 Удирдах ажилтан бүр хариуцсан ажлын хүрээнд “Нэгдсэн менежментийн тогтолцоо”-ны бодлого, зорилт, тогтоосон журам, зааврыг хэрэгжүүлэх
- 5.4 Бүх шатны ажилтан, албан тушаалтан хариуцлага хүлээдэг байх

#### **Зургаа. Хариуцлага**

- 6.1 Дээрх бодлого, зорилтуудыг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх, үүнд шаардагдах нөөцөөр хангах явдал нь байгууллагын удирдлагын үүрэг болно.
- 6.2 Энэ бодлогыг цаг ямагт даган ажиллах нь нийт ажилчдын үүрэг бөгөөд бодлогыг үр нөлөөтэй байлгаж, байгууллагын хэрэгцээнд нийцүүлнэ.
- 6.3 Алба, тасгийн дарга, эрхлэгч нар болон холбогдох ажилтан, албан тушаалтан энэ бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа үйл ажиллагаанд саад учруулсан тохиолдолд сахилгын хариуцлага хүлээх үндэслэл болно.



### ЧАНАРЫН ЗОРИЛТОД ХҮРЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Хүрэх үр дүн	Хариуцах нэгж	Хугацаа
1	ЦССҮТ-ийн удирдлага, байгуулалт, ажиллагааг тасралтгүй сайжруулна. зохион үйл	<ul style="list-style-type: none"> <li>НМТ-ны стандартын шаардлагыг хангаж, баталгаажуулах</li> <li>Чанарын менежментийн тогтолцооны үр нөлөөг үнэлж, тасралтгүй сайжруулах</li> <li>Менежментийн тогтолцооны соёлыг таниулах, сурталчлах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>НМТ-ны стандартын баталгаажуулалтын аудитад хамрагдана.</li> <li>Дотоод аудитыг тогтмол хийнэ.</li> <li>УДШ-г хагас жил бүр хийж, зөвлөмжийг хэрэгжүүлнэ.</li> <li>Удирдлагын тойрон үзлэгийг улирал бүр хийж, зөвлөмжийг хэрэгжүүлнэ.</li> <li>Менежментийн тогтолцооны ач холбогдлыг таниулах мэдээллийн арга хэмжээг жилд 2 удаа зохион байгуулна.</li> </ul>	ЦЧАБА ЗМА	2023.12
2	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж ажиллана.	<ul style="list-style-type: none"> <li>Нэгдсэн менежментийн тогтолцооны бодлогын баримт бичгийг шинэчилж, сайжруулна.</li> <li>Төвийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Шаардлагатай журмыг нэгдсэн менежментийн тогтолцоонд нийцүүлэн шинэчилнэ.</li> <li>Бодлогын баримт бичиг (дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, сувилахуйн хөгжлийн хөтөлбөр, мэдээллийн аюулгүй байдлын хөтөлбөр, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, нийгмийн хамгааллын ) хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийнэ.</li> <li>Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 88%-аас дээш хувьд хүргэж, УЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ.</li> </ul>	ЗМА ЦЧАБА СҮА ЭШМТА	2023.12

			<ul style="list-style-type: none"> <li>Албан тушаалын тодорхойлолтыг менежментийн тогтолцооны бодлогын баримт бичигт нийцүүлнэ.</li> </ul>		
3	Төрөлжсөн мэргэжлийн болон цусны донорын угтуулан сургалт сурталчилгааны сургалтын чанарыг сайжруулна.	<ul style="list-style-type: none"> <li>Цусны донорын угтуулан сургалт сурталчилгааны үр дүнг нэмэгдүүлнэ.</li> <li>Төрөлжсөн мэргэжлийн сургалтын сургалтын чанар, орчинг сайжруулна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Цусны донорын сургалт сурталчилгааны хөтөлбөрийг шинээр, төрөлжсөн мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулна.</li> <li>Хөтөлбөрийн хэрэгжилт болон үр дүнг үнэлэх журмыг боловсруулж батлуулна.</li> <li>Цусны донорын угтуулан сургалт сурталчилгааг танхимын болон цахим хэлбэрээр хийнэ.</li> <li>Боломжит нөөцөөр төрөлжсөн мэргэжлийн сургалтанд суралцагчдын хувь хүний хөгжилд түлхэц үзүүлэхүйц чанарын орчин, дэд бүтцийг бүрдүүлнэ.</li> </ul>	ЭШМТА ЗМА ДЗБТ	2023.12
4	Хүний нөөцийн сургалт хөгжлийг дэмжинэ.	<ul style="list-style-type: none"> <li>Албан тушаалын чадамжид тавих шаардлагыг тодорхойлох</li> <li>Чадамжийг үнэлэх арга, аргачлалыг бий болгох</li> <li>Ажиллагсдын ур чадварыг үнэлэх</li> <li>Үнэлгээний мөрөөр шаардлагатай чадамжийг эзэмшүүлэх арга</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Албан тушаалын чадамжид тавих шаардлагыг боловсруулж батлуулна.</li> <li>Төвийн хэмжээнд чадамжийн үнэлгээ хийх ажлыг нэг удаа зохион байгуулна.</li> <li>Чадамжийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</li> <li>Шинэ ажилтны дасан зохицуулах хөтөлбөрийн журмыг шинэчилж, хэрэгжилтийг сайжруулна.</li> </ul>	ЗМА Бүх алба, тасаг	

		<p>хэмжээг зохион байгуулж, үр нөлөөг үнэлэх</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дунд шатны менежерүүдийн манлайллын чадавхийг хөгжүүлэх</li> </ul>			
5	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагыг ойлгох мэдрэх</li> <li>• Үйлчлүүлэгчийн шаардлагад нийцүүлэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах хувилбарыг санал болгох, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>• Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинд дүн шинжилгээ хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Үйлчлүүлэгчийн санал, гомдлыг хүлээн авах нээлттэй, хэрэглэхэд хялбар сувгуудыг бий болгож, нийтэд таниулна.</li> <li>• Үйлчлүүлэгчийн санал, гомдол, сэтгэл ханамжийн үнэлгээний үр дүнгээр нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, сайжруулалт хийх, хянах арга хэмжээ авна.</li> <li>• Сонирхогч талуудын сэтгэл ханамжийн түвшинг 90%-иас бууруулахгүй ажиллана.</li> </ul>	ЦЧАБА Бүх алба, тасаг	2023.12
6	Цус сэлбэлт судлалын тусламж үйлчилгээг аюулгүй, үр дүнтэй хүргэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>• Аюулгүй, эмчилгээний үр дүнтэй, хүрэлцээтэй цус, цусан бүтээгдэхүүнээр тасралтгүй хангана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Цусны донорын эгнээг өргөжүүлж, байнгын донорын эзлэх хувийг 60%-иас дээш байлгана.</li> <li>• Лабораторийн тусламж үйлчилгээний чиглэл бүрээр олон улсын болон үндэсний чанарын гадаад үнэлгээнд амжилттай хамрагдана.</li> </ul>	ДЗБТ НЛТ ҮТ	2023.12

			<ul style="list-style-type: none"> <li>ЦЦБ-ийг чанарын болон ариун чанарын шинжилгээнд хамруулж, шинжилгээгээр тэнцэлтийг 95%-иас дээш байлгана.</li> </ul>		
7	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангаж ажиллана.	<ul style="list-style-type: none"> <li>ХЭМАБ-ын менежментийн тогтолцоог тасралтгүй сайжруулна.</li> <li>Нийт ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааны соёлыг нэвтрүүлнэ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Жилд нэгээс доошгүй удаа үйл ажиллагааны эрсдэл, боломжийг тооцож, тогтмол сайжруулалт хийж ажиллана.</li> <li>ХЭМАБ-ын сургалтыг шинэ ажилчдад тухай бүр, нийт ажилчдад жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.</li> <li>Ажлын байрны үзлэгийг улирал бүр хийж, гарсан зөрчлийг нөөц бололцоонд тулгуурлан арилгана.</li> <li>Аюулгүй ажиллагааны зааварчилгаанд улирал бүр хяналт тавьж, сайжруулна.</li> </ul>	Бүх алба, тасаг	2023.12